# Соёл Эрдэм

# モンゴル文化教育大学

# SOYOL ERDEM

СУРГАЛТЫН АЛБА: 70118584

2026.03 No.75

ХЭЛТЭЙ БОЛ ДАЛАВЧТАЙ




1 ЭЛСЭЛТ



2 ГАДААД ХАРИЛЦАА

YOUR TRUSTED PARTNER
FOR YOUR EDUCATION AND FUTURE
НОГООН ЖЭЙД
БОЛОВСРОЛЫН ТӨВ

3-4 НОГООН ЖЭЙД БОЛОВСРОЛЫН ТӨВ

## 在日モンゴル国大使館 旧正月·北極星勲章授章式



大野重男理事長



大野重男理事長が、お孫さんの千咲（ちさ）ちゃんとともに喜びを分かち合う。

2月18日、旧正月にあたり、在日モンゴル国大使館において、オフナーギーン・フレルスフ大統領閣下の命令によるモンゴル国北極星勲章の授章式が厳粛に執り行われました。

この栄えある勲章は、大野　重男氏（95歳・元公益財団法人ハーモニィセンター理事長・創立者）に授与されたものであり、バンズラグチ・バヤルサイハン特命全権大使より伝達されました。

大野重男氏は体調不良のためご出席が叶わず、上村代表理事が代理で拝受されました。

本受章は、モンゴル国における識字教育事業や日本語教育への長年にわたる多大なる貢献が高く評価されたものであり、その功績は両国友好の歴史に深く刻まれるものであります。

心よりお祝い申し上げます。誠におめでとうございます。

2026年3月12日

## 小学校　中学校　高等学校










**Холбоо барих утас: 70118589, 99533738**

НЕБ-ын Соёл Эрдэм сургууль 9-р сараас эхлэх шинэ хичээлийн жилийн элсэлтээ албан ёсоор эхлүүллээ. 2026 оны хичээлийн шинэ жилээс тус сургууль нь **бага** болон **дунд** ангийн сурагчдын элсэлтээ албан ёсоор эхлүүлж байгаагаараа онцлогтой болж байна.

モンゴル文化教育大学附属高等学校では、9月から始まる新学期の生徒募集が正式に開始されました。

さらに、2026年度新学期より、小学校および中学校の生徒募集も正式にスタートしました。

本校は今後も教育体制の充実を図り、より多くの児童・生徒に質の高い教育機会を提供してまいります。


**СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛЬ**

**モンゴル文化教育大学**

**БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨР**

*Гадаад хэлний орчуулга*
*Программ хангамж*
*Олон улс, орон судлал*
*Аялал жуулчлал*
*Эдийн засаг*

**МАГИСТРЫН ХӨТӨЛБӨР**

*Гадаад хэл шинжлэл*

**ЗЭРГИЙН БУС СУРГАЛТ**

*Япон хэлний анхан, дунд шатны дамжаа*
*Соёл Эрдэм дээд сургуулийн CISCO академи*

**ХАЯГ:** *СБД, 1 дүгээр хороо, Элчингийн гудамж 15а*
*Embassy One tower - 4,5 дугаар давхарт*

**УТАС: 70118584, 99085696**

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СОЁЛ ЭРДЭМ СУРГУУЛЬ**

**モンゴル文化教育大学附属高等学校**

**Япон улсын хөрөнгө оруулалттай**
**ЯПОН ХЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТӨРӨЛЖСӨН СУРГУУЛЬ НЬ**

*I-XII ангидаа элсэлт авч байна.*

Энэ QR кодыг уншуулаад бүртгүүлээрэй

*Магистр* *Бакалавр* *НЕБ-ын Соёл Эрдэм сургууль* *Дамжаа*

**ХАЯГ:** *СБД, 1 дүгээр хороо, Олимпын гудамж 15а*
*НЕБ-ын Соёл Эрдэм сургууль*

**УТАС: 70118589, 99533738**

## НЕБ-ЫН СОЁЛ ЭРДЭМ СУРГУУЛЬ НЬ ЯПОН УЛСЫН КОМАЗАВА ОХИДЫН ДУНД, АХЛАХ СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХААР БОЛЛОО

### モンゴル文化教育大学附属高等学校と駒沢学園女子中学校･高等学校との間で両校の文化交流に関する総括協定書に調印しました。

2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Соёл Эрдэм дээд сургуулийн УЗ-ийн дарга Макихара Соичи Соёл Эрдэм дээд сургуулийн дэргэдэх НЕБ-ын Соёл Эрдэм сургууль болон Японы Комазава охидын дунд, ахлах сургуулийн захирал Цүчияа багшийн хамт хоёр сургуулийн соёлын солилцооны хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурлаа.

Энэхүү гэрээний дагуу энэ зун Комазава эмэгтэйчүүдийн их сургуулийн оюутнууд болон Комазава охидын дунд, ахлах сургуулийн сурагчид Монгол Улсад ирж танилцах аялал хийх бөгөөд оюутан, сурагчдын өргөн хүрээний хамтын солилцооны хөтөлбөрийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн манай ахлах сургуулийн сурагчид Комазава сургуульд суралцах боломж нээгдэж байна.

2026年1月20日、牧原理事長は、モンゴル文化教育大学附属高等学校と駒沢学園女子中学校・高等学校との間で、両校の文化交流に関する総括協定書に調印しました。

また、本協定書に基づき、今年の夏には駒沢女子大学の大学生と駒沢学園女子中学校・高等学校の生徒たちがモンゴルを訪れ、修学旅行を実施する予定です。これを機に、両校の学生・生徒による学生生徒の交換等幅広い交流活動を企画しています。


駒沢学園女子中学校・高等学校諸関係者


左から牧原理事長と土屋校長先生

## БАЯР ХҮРГЭЕ! МАНАЙ АХЛАХ СУРГУУЛИЙН СУРАГЧ "ЯПОН ВЕЛНЕСС МИЯАГИ" АХЛАХ СУРГУУЛЬД ШИЛЖИНСУРАЛЦАХААР БОЛЛОО.

### おめでとうございます! 本学附属高等学校の生徒が、日本ウェルネス宮城高等学校に編入し、勉強することになりました


*О.Баясгалан*

Өнөөдрийн сурах маргаашийн амжилт

Сайн байна уу? Намайг О.Баясгалан гэдэг 15 настай. Япон улсын Токио хотын Нихон Вэлнесс Мияаги ахлах сургуульд суралцах болсондоо маш их баяртай байна. Би өмнө нь Япон улсад 2 жил гаруй хугацаанд амьдарч байсан. Японы сургуулийн сурах орчин нь маш гоё санагдсан. Багш нарын заах арга барил их таалагдсан. Хүмүүс нь маш цэвэрч, соёлтой байдаг нь надад гоё сэтгэгдэл төрүүлсэн. Ирээдүйд Япон улсын их сургуульд суралцаж өндөр боловсрол эзэмших хүсэлтэй. Тиймээс ахлах сургуулийнхаа хугацаанд япон хэлээ сайн сурч ирээдүйд эх орондоо хэрэгтэй мэргэжил эзэмшихийг зорьж байна. Боловсролын систем нь өндөр хөгжсөн Япон улсад суралцах боломж олгож, дэмжиж тусалсан сургуулийнхаа багш удирдлагуудад чин сэтгэлээсээ талархаж байна.

はじめまして。私の名前は0.バヤスガランと申します。15歳です。このたび、日本ウェルネス宮城高等学校に入学することができ、大変うれしく思っています。私は以前、日本に 2年以上住んでいたことがあります。日本の学校の学習環境はとても素晴らしく、先生方の教え方もとても印象に残りました。また、日本の人々がとても清潔で礼儀正しいことにも深く感動しました。将来は日本の大学で学び、高い教育を受けたいと考えています。そのため、高校生活の中で日本語をしっかり勉強し、将来は母国の役に立つ専門分野を身につけたいと思っています。教育制度が非常に発達している日本で学ぶ機会を与えてくださり、支えてくださった学校の先生方や関係者の皆様に、心より感謝しております。


*Э.Мөнгөнтовруу*

Сайн байна уу. Намайг Э.Мөнгөнтовруу гэдэг. 12 дугаар ангийн сурагч. Япон улсын Нихон Вэлнесс Мияаги ахлах сургуульд суралцах болсондоо маш их баяртай байна. Би БНХАУ –ын Өвөрмонголын Өөртөө засах орноос ирээд 2 дахь жилдээ суралцаж байгаа. Өмнө нь Сурагч солилцооны хөтөлбөрөөр Япон улсад 14 хоногийн хугацаатай явж байсан. Ахлах сургуулиа амжилттай төгсөж цаашид Япон улсад их сургуульд суралцан мэргэжил эзэмших зорилготой. Энэ хугацаанд япон хэлээ улам сайжруулж, сахилга баттай хичээнгүй суралцаж өөрийгөө хөгжүүлнэ. Надад ийм сайхан боломж олгож дэмжиж тусалж байгаа багш нартаа баярлалаа.

こんにちは。私はE.ムンゲントブロと申します。現在、高校3年生です。日本ウェルネス宮城高等学校で学ぶことになり、大変うれしく思っております。私は中国の内モンゴル自治区から来て、現在こちらで2年目の勉強をしています。これまでに、学生交換プログラムで14日間日本を訪れた経験があります。高校を無事に卒業した後は、日本の大学に進学し、専門分野を学びたいと考えています。そのために、この期間で日本語をさらに上達させ、規律を守りながら一生懸命勉強し、自分自身を成長させていきたいと思います。このような素晴らしい機会を与え、支えてくださっている先生方に心より感謝申し上げます。

## ЯПОН УЛСЫН ТОКИВА ИХ СУРГУУЛИЙН БАГШ, ДОКТОР ПРОФЕССОР МАЦУБАРА КАЦУШИ ХҮРЭЛЦЭН ИРЭВ

### 本学と交流のある常盤大学の松原教授が、はるばる日本からモンゴルを訪れ、3月2日に本学の学生･生徒に講演を行ってくださいました。松原先生に心より御礼申し上げます。




左からD.エンフチメグ教務課主任、松原教授、D.エルデニチメグ学長、ムンフツェツェグ先生





Соёл Эрдэм дээд сургуулийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд, тус сургуулийн урилгаар Япон улсын Токива их сургуулийн багш, доктор профессор Мацубара Кацуши хүрэлцэн ирэв. Профессор Мацубара Кацуши Соёл Эрдэм дээд сургуулийн удирдлага, хамт олонтой уулзаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Мөн түүнчлэн СЭДС болон НЕБ-ын Соёл Эрдэм сургуулийн оюутан, сурагчидтай уулзаж, Япон улсын дээд боловсролын тогтолцоо онцлог, Япон улсад суралцах боломж, тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгсөн нь ач холбогдолтой байв.

## СОЁЛ ЭРДЭМ ДЭЭД СУРГУУЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ ЦУВРАЛЫН V БОТЬ ХЭВЛЭГДЭВ

### モンゴル文化教育大学学術論文集第5巻が発行された




Соёл Эрдэм дээд сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг цувралын V боть буюу 2026 оны эхний боть 2026 оны 3-р сард хэвлэгдлээ. Энэ ботид Соёл Эрдэм дээд сургуулийн профессорын багийн гишүүд болох Монгол, Япон, БНХАУ, ОХУ-ын эрдэмтэн судлаачдын бичсэн Монгол-Япон харьцуулсан хэл шинжлэл, орчуулга зүй, Утга зохиол судлал болон Мэдээллийн технологи, Боловсрол судлалын эрдэм шинжилгээний өгүүллүүд оржээ. Тухайлбал Соёл Эрдэм дээд сургуулийн Япон судлалын тэнхимийн багш, доктор, профессор Ц.Пүрэвсүрэнгийн "Соёлын антропологи ба "Монгол хүн" судлал", Бээжин их сургуулийн багш доктор, профессор Дулааны "Учиртай гурван толгой" ба "Бээжин ший", ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Төвөд, Будда судлалын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн секторын ажилтан Г.Н.Чимитдоржиевагийн "Монгол хэлнүүд дэх bur-/pur- язгуур бүтээврийн утга зүй", Өвөр Монголын Багшийн их сургуулийн Монгол судлалын сургуулийн багш, доктор Илчийн "Япон хэлний тусах ба эс тусах үйл үгийн тухай", Соёл Эрдэм дээд сургуулийн Япон судлалын тэнхимийн зочин профессор Жаргалын "Япон хэлний тусах ба эс тусах үйл үгийн тухай", Буриад улсын их сургуулийн багш доктор, дэд профессор Л.Ц.Халхаровагийн "Ц.Жамцараногийн "Аяллын өдрийн тэмдэглэл" [1903–1907]-ийн орон зай – цаг хугацааны архитектоник бүтэц", Соёл эрдэм дээд сургуулийн багш, доктор, профессор Н.Галиймаагийн "XX-XXI зууны үргэлжилсэн үгийн зохиолд монгол эмэгтэй дүрийн хувьслыг харуулсан нь: (Д.Нацагдорж, С.Эрдэнэ, Ч.Лодойдамба болон орчин үеийн зохиолчдын бүтээлээс жишээлэн), Соёл Эрдэм дээд сургуулийн Мэдээллийн технологийн тэнхимийн багш Б.Мөнхчимэгийн "Дээд боловсрол дахь хиймэл оюуны нөлөө ба moodle системд хиймэл оюуныг нэгтгэх боломж", ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн багш, доктор Д.Бямбадоржийн "Монгол улсын кибер аюулгүй байдлын цаашдын чиг хандлага эрсдэл, бууруулах боломж" ... зэрэг эрдэм шинжилгээний 24 өгүүлэл орсон байна.

Тоон үзүүлэлт гаргавал нийт өгүүллийн 60%-г манай сургуулийн багш нарын бүтээл эзэлж байгаа ба үүний дотор Хэл шинжлэл, харьцуулсан хэл шинжлэлийн өгүүллүүдийн 66%, Утга зохиол судлалын өгүүллүүдийн 22%, IT судлалын өгүүллүүдийн 100%, Боловсрол судлалын өгүүллүүдийн 75% Шүүмж судлалын өгүүллийн 100%-ийг манай багш нарын өгүүлэл эзэлж байна.

Эдгээр эрдэм шинжилгээний өгүүллүүд нь СЭДС-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэл болсон Япон хэл утга зохиол судлал, орчуулга зүй, Мэдээллийн харилцааны технологи, Монгол утга зохиол судлалын чиглэлээр байгаа ба СЭДС-ийн Хөгжлийн бодлого [2025-2030], Стратеги төлөвлөгөө [2022-2027]-д заасан эрдэм шинжилгээний үйл ажиллагааны бодлогын хэрэгжилтийн бодит үр дүн болж байгаа юм.

Та бүхэн Соёл Эрдэм дээд сургуулийн Эрдэм шинжилгээний бичиг цувралын бүрэн ботиудтай soyolerdem.edu.mn веб хуудсаар орж уншиж болно.

СЭДС-ийн Эрдэм шинжилгээ, инновацын алба

**МАНАЙ АХЛАХ СУРГУУЛЬ ХОНКОНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ "НОГООН ЖЭЙД" БОЛОВСРОЛЫН ТӨВТЭЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛСНААР БҮХ ХИЧЭЭЛИЙГ АНГЛИ ХЭЛЭЭР ЗААХ АХЛАХ АНГИЙН САЛБАР БҮЛЭГТЭЙ БОЛЛОО.**

本学附属高等学校は、香港資本の学習塾と協定を締結しました。それによって、新学期から英語による全授業を行う分校が開設されることとなり、本校の教育発展において大きな前進となりました。

НОГООН ЖЭЙД
БОЛОВСРОЛЫН ТӨВ



# YOUR TRUSTED PARTNER

FOR YOUR EDUCATION AND FUTURE

**SINCE 2013**

## YOUR TRUSTED PARTNER

FOR YOUR EDUCATION AND FUTURE

НОГООН ЖЭЙД
БОЛОВСРОЛЫН ТӨВ

"Ногоон Жэйд" боловсролын төв нь жил бүр 6,000 гаруй оюутан, сурагчдад мэргэжил, сургалтын хөтөлбөр, сургуулиа хэрхэн сонгох мөн тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хэрхэн хамрагдах талаар үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээлэл өгдөг билээ. Бид Монголын хүүхэд залууст дэлхийд танигдсан эрдэм мэдлэгийг эзэмших боломжийг бүрдүүлж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын хөтөлбөрийг Монгол улсад нэвтрүүлэх зорилт дэвшүүлэн ажилладаг. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд бид дэлхийн шилдэг их сургуулиудын захирал, төлөөлөгчдийг урьж, жилд 2 удаа бүх нийтийг хамарсан боловсролын үзэсгэлэнг зохион байгуулснаар олон нийтэд эх сурвалжаас нь үнэн бодитой мэдээллийг олгодог юм. Ингэснээр бид зөвхөн танд тохирсон сургалтын хөтөлбөр, их сургуулийг чиглүүлж өгдөг. "Ногоон Жэйд"-тэй нэгдэж ирээдүйдээ хөрөнгө оруулаарай.

Монголын оюутан, сурагчдыг дэлхийн шилдэг их сургуулиудад элсэн сурахад тусалж ажилласан 10+ жилийн туршлага

Дэлхийн шилдэг 400+ сургуультай хамтарч ажилладаг

Бодит үр дүн (Нийт оюутнуудын 98% нь хүссэн сургуульдаа элсэн ордог)

Бүх сурагчдын 99% нь амжилттай визээ авдаг

Таны боловсролын найдвартай зөвлөх

Өөрийн хүссэн түвшинд 150-500 мэргэжлээс сонгон суралцах боломж



НОГООН ЖЭЙД
БОЛОВСРОЛЫН ТӨВ

## НОГООН ЖЭЙД

Танд дараах үйлчилгээг санал болгож байна:



### KID'S ENGLISH
БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТ

Бага насны хүүхдийн гадаад хэлийг сурах чадвар насанд хүрэгчдийнхтэй харьцуулахад өндөр байдаг учир хүүхдэд шинэ хэл заахдаа бүтэц, хэллэг, дүрмийн хувьд зөв суурийг тавьж өгвөл насан туршийн мэдлэг болж үлддэг. Тиймээс бид олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу хүүхдийн насны онцлог, сэтгэн бодох чадварт тулгуурлан 5 түвшинд англи хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулан явуулж байна.

### JUNIOR ENGLISH
ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТ

Өсвөрийн англи хэлний сургалт нь 12-14 насны хүүхдүүдийн сэтгэхүйн онцлогт тохируулан англи хэлийг сонирхолтой байдлаар заан дүрмийн мэдлэг болон хэлний үндсэн 4 чадварыг зэрэг хөгжүүлнэ. Мөн гадаад орчин, байгаль дэлхий болон танин мэдэхүйн мэдлэгт нь хувь нэмэр оруулахуйц үгийн сан, унших материал, видео зэргийг хичээлийн хөтөлбөртөө багтаасан.

### SEMI-INTENSIVE ENGLISH
ХАГАС ЭРЧИМЖҮҮЛСЭН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТ

Бид ахлах ангийн сурагчид болон насанд хүрэгчдэд зориулсан Англи хэлний ерөнхий мэдлэг олгох 5 шатлал бүхий сургалтын хөтөлбөр боловсруулан Англи, Монгол багштай хичээллэж байна. Та өөрт тохирсон түвшнээс эхлэн IELTS-ийн оноондоо хүрэх хүртлээ сурах боломжтой.

### IELTS ШАЛГАЛТАД
БЭЛДЭХ СУРГАЛТ

Тус хөтөлбөр нь англи хэлний шалгалтад өндөр оноо авахад шаардлагатай дадал системийг суралцаж, цагийг зөв хуваарилж, шалгалтын асуултуудад оновчтой хариулах чадварыг эзэмшүүлэх зорилготой хөтөлбөр юм.

### NIFY
ОЛОН УЛСЫН СУУРЬ ХӨТӨЛБӨР

Navitas International Foundation Year суурь хөтөлбөр нь Австралийн Eynesbury College-ээс Монгол улсад албан ёсоор хэрэгжүүлж буй хөтөлбөр бөгөөд үргэлжлүүлэн Австрали улсад суралцах зорилготой сурагчдад зориулсан хөтөлбөр юм.

### OXFY
ОЛОН УЛСЫН СУУРЬ ХӨТӨЛБӨР

Oxford олон улсын суурь хөтөлбөр нь Англи улсад суралцах хүсэл, тэмүүлэлтэй олон улсын оюутан, сурагчдыг бэлдэх зорилготой хөтөлбөр юм. Тус хөтөлбөрт суралцснаар сурагчид мэргэжлийн багш ажилчдын туслалцаа доор их сургуулийн түвшний хичээлийн хөтөлбөрийг үзэж, үргэлжлүүлэн их сургуульд амжилттай суралцахад шаардлагатай чадваруудыг эзэмшдэг.

### БОЛОВСРОЛ ЗУУЧЛАЛ

Англи, Америк, Австрали, Канад, Швейцар, Хятад, Голланд, Унгар, Сингапур, Япон зэрэг орнуудын 500 гаруй сургуулиуд руу 150-500 гаруй мэргэжлээс сонгон тэтгэлэгтэй суралцах зуучлалын үйлчилгээ.

## ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛИУДАД СУРАЛЦАХ ХУВИЛБАРУУД

### Бакалаврын түвшинд суралцах хувилбар

- Үргэлжлэх хугацаа: 3-4 жил (Хос мэргэжил, honours degree 4-5 жил)
- Семестр – 2 (зарим тохиолдолд 3 семестр)
- Хичээл эхлэх хугацаа: 1 сар, 3 сар, 5 сар, 9 сар, 10 сар

Study option 1 (UK or Australia)

High School Completion of year 11 or 12 → Foundation program → Year 1 University → Year 2 University → Year 3 University

Study options 2 (USA, CAN, EU or other countries)

High School Completion of year 12 or equivalent → Year 1 University → Year 2 University → Year 3 University → Year 4 University

### Магистрын түвшинд суралцах хувилбар

- Үргэлжлэх хугацаа: 1 – 2 жил
- Семестр – 2 (зарим тохиолдолд 3 семестр)
- Хичээл эхлэх хугацаа: 1 сар, 3 сар, 5 сар, 9 сар, 10 сар

Study option 1 (UK or Australia)

Bachelor Degree → Year 1 Masters Degree → Year 2 Masters Degree

Study option 2

Bachelor's degree → Pre-master's → Year 1 Master's degree → Year 2 Master's degree

### Магистрын түвшинд суралцах хувилбар

- Үргэлжлэх хугацаа: 3 жил (докторын ажлыг хэлэлцэх – 1 жил)
- Семестр – Докторын түвшин горилогчид нь хичээлд хамрагдахын оронд хариуцсан зөвлөх профессорын хяналтанд хамтарч ажиллана.
- Хичээл эхлэх хугацаа: Зөвлөх профессортойгоо харилцан тохиролцоно.



Сайн байцгаана уу? Намайг Манлай гэдэг. Би 2025 оны 03 сард Western Sydney их сургуульд элсэн суралцаж байна. Миний хувьд Ногоон Жэйдэд анх дунд ангидаа Англи хэлний сургалтад суух гэж орж ирсэн. Сургалтны зааж байгаа арга барил, орчин нь маш их таалагдсан учир би үргэлжлүүлэн сурсаар ахлах ангидаа IELTS-ийн сургалтад суусан. IELTS-ийнхаа сургалтад олон зүйл сурсны эцэст би IELTS-ийн шалгалтаа өгч 7 оноо авсан. Би Ногоон Жэйдээр дамжуулж Австралийн Сиднеэй хотод байдаг UTS, Macquarie, Western Sydney гэх сургуулиуд руу өргөдлөө явуулж бүх сургуулиудаад нь тэнцсэн. Би WSU сургуулийг сонгосон учир нь бизнесээр сурах учраас WSU сургуулийн бизнесийн факултет нь Австралид их өндөрт үнэлэгддэг. Бас түүнчлэн кампус дээр нь олон томоохон компаниуд байрладаг учир би сурч байхдаа бас ажил хийж дадлага хийх боломжтой учраас WSU-г сонгосон. WSU-ээс би 3,000$-ийн тэтгэлэг авсан.

**Б. Манлай**
**Western Sydney University**
Bachelor of Business



Hii, Намайг Буянзаяа гэдэг. Одоо 18 настай. 2025 оны 01 сард Английн Swansea University-д элсэн орж суралцаж байна. Анх 2024 оны 01 сард Ногоон Жэйд дээр очиж байсан бөгөөд найдвартай гарцаар дамжуулан хүссэн сургуульдаа орно гэж бодоход их сэтгэл хөдөлж билээ. Ингээд харахад нэг жил харвасан сум шиг өнгөрчээ. Эхлээд NIFY хөтөлбөрт суралцсан, дараа нь сургуулиа сонгон, бүх хэрэгтэй гэсэн бичиг баримтуудыг цуглуулах нь чамгүй цаг хугацаа шаардсан шүү. Харин дараа нь виздээ apply хийгээд хариугаа авах тэр үед "Хүүеээ би чинь үнэхээр явах гэж байгаа билүү" гэж бодож билээ. Энэ бүх цаг үеүдэд хамтдаа байж туслан дэмжсэн Ногоон Жэйдийн хамт олондоо маш их баярлалаа.

**Э. Буянзаяа**
**Swansea University**
Bachelor of Business Analytics



Ногоон Жэйд сургалтын төв нь надад маш их боломжийг нээж өгсөн. Энд сурсанаар би хүссэн улсдаа, хүссэн сургуульдаа орж чадсан. Хамт олон, багш нар маань найрсаг тусч байсны ачаар амжилттай NIFY хөтөлбөрөө дуусгаж чадсан. Ногоон Жэйд сургалтын төвд явсандаа маш их сэтгэл хангалуун байдаг. Ногоон Жэйд сургалтын төвийн хамт олонд маш их баярлалаа. Хамт сурсан ангийхандаа амжилт хүсье.

**А. Ингүүнэм**
**University of Portsmouth**
Bachelor of Law







## Канад улсыг сонгон суралцах шалтгаан

Канад улс нь амьдралын өндөр стандарттай орнуудын нэг юм. Олон улсын оюутнуудын хувьд эрх тэгш байдал, шударга ёс, хүний эрхийг хүндэтгэх, амар тайван байдал зэрэг Канадчуудын эдэлдэг бүхий л эрхийг эдэлдэг.



### Уян хатан, чанартай боловсрол

Канад нь бага сургуулиас эхлээд их сургуулийн түвшин хүртэл өндөр чанартай боловсрол, олон төрлийн судалгааны боломжийг олгодог гэдгээрээ алдартай. Канадын 7 их сургууль дэлхийн шилдэг 200-д багтдаг.

### Олон талт, найрсаг аюулгүй орчин

Канад бол нээлттэй, аюулгүй, соёлын олон талт нийгэм юм. Олон улсын оюутнууд дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн олон соёлтой танилцаж, найрсаг дотно орчинд хөгжих боломжтой. Канадад 250 гаруй угсаатны гарал үүсэл оршдог бөгөөд дэлхийн 200 гаруй орны хэл, соёл тогтнодог.

### Санхүүгийн боломж

Канадад олон улсын оюутнуудад сургалтын төлбөрөө төлөхөд туслах тэтгэлэг, ажлын олон сонголтууд бий. Сургалтын дийлэнх хөтөлбөрүүд нь суралцах хугацаандаа практик туршлага олж авах цалинтай төслийн ажил эсвэл дадлагын ажил хийх боломжийг санал болгодог. Мөн олон улсын оюутнууд суралцах хугацаандаа ажиллах эрхтэй бөгөөд сурсны дараа төгсөлтийн дараах ажлын виз авах боломжтой.

## Англи улсыг сонгон суралцах шалтгаан

Их Британийн их сургуулиуд дэлхийн хамгийн шилдэг эрдэм шинжилгээний стандарттай бөгөөд Дэлхийн шилдэг 10 их сургуулийн дөрөв нь Их Британиас гаралтай Та Их Британид суралцаж байхдаа сурах бичиг судлахаас илүү практик болон хэрэгцээнд суурилсан мэдлэгийг илүүд үздэгийг олж мэдэх болно. Энэ нь танд сонгосон мэргэжлээрээ шүүмжлэлтэй сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх ур чадвар, бүтээлч чадварыг эзэмших боломжийг олгодог.

- Гадаад оюутан хичээлийн үед долоо хоногт 20 цаг, хичээл амарсан үед бүтэн цагаар ажиллах боломжтой. Энэ нь оюутнуудад цагийн ажил эсвэл дадлага хийх, суралцах явцдаа шинэ ур чадвар эзэмших, мөнгө олох боломжийг олгодог.
- Их сургуулийн ихэнх хөтөлбөрүүд танд сургалтынхаа нэг хэсэг болгон дадлагын ажил хийлгэдэг бөгөөд энэ нь таныг төгсөхөд тань өрсөлдөх давуу талыг өгөх нь дамжиггүй.
- Их Британийн их дээд сургуульд бакалавр, магистрын зэрэг амжилттай төгссөн олон улсын оюутан бүр тус улсад үргэлжлүүлэн 2 жил ажиллах, туршлага хуримтлуулах боломжтой. Харин докторын зэрэг хамгаалсан оюутнуудын хувьд энэ хугацаа гурван жил хүртэл үргэлжилдэг.



### Боловсролын чанар

Чанарын баталгаажуулалтын агентлаг – The Quality Assurance Agency (QAA) нь Их Британи дахь бие даасан байгууллага бөгөөд тус улсын бүх их, дээд сургууль, коллежийн боловсролын стандартыг тогтмол үнэлдэг. Тус байгууллага нь аудитын болон сургалтын хөтөлбөрөөр дээд боловсролын байгууллагуудын гүйцэтгэлийг шалгахаас гадна боловсролын шилдэг хэрэглээг тодорхойлоход тусалдаг байна.

### Санхүүгийн давуу тал

Та бакалаврын хөтөлбөрийг гурван жилийн дотор дүүргэх боломжтой бөгөөд магистрын зэргийг ердөө нэг жилийн дотор дуусгах боломжтой. Энэ нь таны цагийг хэмнээд зогсохгүй сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зарцуулах санхүүд тань багагүй дэмжлэг болдог.







## Америк улсыг сонгон суралцах шалтгаан

**Чанартай боловсрол** – АНУ нь Харвард, Массачусетсийн Технологийн Их Сургууль, Стэнфорд зэрэг дэлхийн шилдэг их сургуулиудтай бөгөөд шилдэг хөтөлбөрүүд болон хамгийн сүүлийн үеийн судалгааны ажлыг явуулдаг.

**Өргөн хүрээний сургалтын хөтөлбөр** – Америкийн их дээд сургуулиуд олон төрлийн мэргэжлийн хөтөлбөр явуулдаг бөгөөд энэ нь оюутнуудыг өөрсдийн хүсэл сонирхол, ажил мэргэжлийн зорилгод нийцүүлэн боловсрол эзэмших боломжоор хангадаг.

**Ажил мэргэжлийн боломжууд** - АНУ нь дадлага хийх, Нэмэлт практик сургалт (OPT) болон төрөл бүрийн салбаруудад, ялангуяа технологи, бизнес, эрүүл мэндийн салбарт ажиллах боломжийг олгодог.

**Соёлын олон талт байдал** – АНУ-д суралцах нь олон соёлт орчинтой танилцаж, оюутнуудад дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн хүмүүстэй харилцах харилцааг бий болгоход тусалдаг.

**Хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж -** АНУ-ын их дээд сургуулиуд орчин үеийн номын сан, судалгааны лаборатори, дэвшилтэт технологийг санал болгож, тав тухтай сургалтын орчинг бүрдүүлдэг.



## Австрали улсыг сонгон суралцах шалтгаан

Австралид суралцаж буй
Олон улсын оюутнууд хоёр долоо хоногт 48 цаг ажил хийх боломжтой. Түүнчлэн их сургуулиа төгссөний дараа 2 – 5 жил ажиллаж, амьдрах боломжтой.

Дэлхийн шилдэг 100 их сургуулийн 9 нь Австралид байдаг.
QS World University Rankings 2025

Дэлхийн шилдэг 100 их сургуулийн 9 нь Австралид байдаг.
QS World University Rankings 2025

Дэлхийн шилдэг 100 их сургуулийн 9 нь Австралид байдаг.
QS World University Rankings 2025



Австралийн их сургуулиуд нь оюутнуудад өндөр түвшний судалгаа хийх, туршилт явуулах боломж олгосон дэлхийн хамгийн шилдэг лабораториуд болон судалгааны төвүүдтэй. Жишээлбэл, Сиднейн их сургууль болон Күинслендийн их сургууль нь нанотехнологи, сэргээгдэх эрчим хүч, эрүүл мэндийн шинжлэх ухаан зэрэг салбарт тусгай судалгааны төвүүдтэй байна.